



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 458

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн, нийт 67,559,197.78 (жаран долоон сая таван зуун тавин есөн мянга нэг зуун ерэн долоон төгрөг далан найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.“Эрдэнэс Монгол” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогтод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005921
23-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 09 дугаар сарын 21-ны өдрийн
 458 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ СЭЛБЭГЭЭР АШИГЛАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинь нэр, марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 423 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)
1	Ниссан Навара пикап, 75-63 УНР	2011/2014	28,202,603.52	28,202,603.52	-	2,500,000.00
2	Форд ренжер, 04-85 УНӨ	2011/2014	39,356,594.26	39,356,594.26	-	10,000,000.00
	Нийт үнэ		67,559,197.78 (жаран долоон сая таван зуун тавин есөн мянга нэг зуун ерэн долоон төгрөг далан найман мөнгө)	67,559,197.78 (жаран долоон сая таван зуун тавин есөн мянга нэг зуун ерэн долоон төгрөг далан найман мөнгө)	-	12,500,000.00 (арван хоёр сая таван зуун мянга)